



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,  
Утас: 26 28 30, 26 61 71, Факс: (976-11) 32 09 43, 26 62 86,  
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2015. 04. 28 № 01/2448  
танай -ны № 5/3475

БАЙГАЛЬ ОРЧИН,  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА С.БАТБОЛД ТАНАА

Танай 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн  
5/3475 тоот албан бичгийн хариу мэдээллийг  
хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.



000357

## МЭДЭЭЛЭЛ

Ой, хээрийн түймэр болон байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай

Илтгэгч: Д.Оюунхорол, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд

### I. Ой, хээрийг түймрээс хамгаалах талаар

#### 1.1. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах бодлого, эрх зүйн орчинг сайжруулах талаар:

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын бодлого, эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор Ойн тухай хуулийг шинэчлэн найруулж, Засгийн газрын 106-р тогтоол гарган дор дурдсан журмуудыг баталж хэрэгжилтийг ханганд ажиллаж байна. Үүнд:

- “Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”
- “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам”
- “Сум дүүргийн нутаг дэвсгэрт ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслийн жагсаалт”
- “Ой, хээрийн түймрийг унтраах ажилд оролцож буй иргэдийн хувийн хангамжид байх зүйлс, тэдний заавал эзэмших арга техникийн жагсаалт” зэрэг болно.

Мөн түүнчлэн Улсын хил болон хил дамнан гарч байгаа ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажилд онцгой анхаарал хандуулан ажиллаж ирлээ.

Тухайлбал, Хил хамгаалах ерөнхий газартай 2013-2016 онд хамтран ажиллах тухай “Санамж бичиг” байгуулав. Үр дүнд нь улсын хил дамнан гарч байгаа түймрээс хамгаалах зориулалт бүхий 400 км урт 10 метр өргөнтэй харлуулсан зурvasыг Сайдын багцаас санхүүлж, Дорнод, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын ОХУ-тай хиллэх улсын хилийн дагуу байгууллаа.

Түймрийн тархалтыг хориглох үлээгч аппарат, үүргэн шүршигч, цуравдагч аппарат, 1500 литрийн багтаамжтай ус зөөвөрлөх резинэн сав, усны насос зэрэг 5 нэр төрлийн 75 ширхэг 34.8 сая төгрөгийн багаж хэрэгслийг ХХЕГ-т хүлээлгэн өглөө.

Дээр дурдсан нэр төрлийн нийт 166 880 000 төгрөгний үнэ бүхий түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах багаж, төхөөрөмжийг аймгуудын БОАЖГ болон сум дундын ойн ангиудад олгов.

Ойг түймрээс хамгаалах тухай Монгол улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2014.09.03-ны өдөр батлагдан хэрэгжиж эхэллээ. Хэлэлцээрийн хүрээнд хил зэргэлдээх аймаг, сумдууд түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах, түүнээс учрах хохирлыг багасгах зэрэг ажлыг зохион байгуулах, сайжруулах, түймэртэй тэмцэхэд харилцан туслалцаа үзүүлэх зэргээр хамтран ажиллаж байна.

#### 1.2. Түймрийн цагийн байдалтай уялдуулан зохион байгуулсан ажлын талаар:

- Монгол Улсын Шадар сайд, БОНХАЖ-ын сайдын Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай 2015 оны 38, А-141 дугаарын хамтарсан тушаал гаргаж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх үүрэг, даалгаврыг бүх шатны Засаг дарга, бусад холбогдох байгууллагуудад үүрэгжүүлэн хүргүүллээ.
- Ой, хээрийн түймрээс хамгаалах үндэсний зөвлөл болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, эрчимжүүлэх, түймрийн эрсдэлтэй бүс нутгуудад байгаа иргэдийн амь нас, аж ахуйн нэгж байгууллагуудын өмч хөрөнгийг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Мөнххаан, Дорнод аймгийн Баянуул, Хэнтий аймгийн Дадал, Норовлин сумдад зохион байгуулав.
- БОНХАЖЯ-ны түймрийн шуурхай жижүүрийг түймрийн эрсдэл ихтэй улирал болох гуравдугаар сарын 25-наас эхлэн үйл ажиллагааг нь эхлүүлж аймаг орон нутгийн Байгаль орчны газрууд, Цаг уур орчны шинжилгээний газар, ОБЕГ, ХХЕГ болон Улсын тусгай хамгаалалттай газруудтай хамтран мэдээ мэдээлэл солилцон ажиллаж байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр гол түймрээс урьдчилан сэргийлэх санамж, сурталчилгааг тогтолцойж байж байна.
- БОНХАЖЯ-ны Цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн сансрын хиймэл дагуулын мэдээгээр Монгол орны газар нутгийн хэмжээнд гарч буй түймрийн байршлыг илрүүлэн ОБЕГ-т мэдэгдэж, хуурайшлын зэргийг өдөр бүр гарган ажиллаж байна. Энэ хугацаанд хиймэл дагуулын зургаар 89 удаагийн түймрийг илрүүлж ОБЕГ-т мэдээлсэн болно.
- БОНХАЖЯ-ны Ус цаг уур орчны шинжилгээний газар хуурайшлын зэрэг өндөр буюу аюултай, нэн аюултай зэрэгт хүрсэн газруудад үүлэнд зориудаар нөлөөлөн бороо оруулах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх хөдөлгөөнт экспедиц, газрын генераторуудын үйл ажиллагааг 2015 оны дөрөвдүгээр сарын 1-нээс эхлэн ажиллуулж байна. Өнөөдрийн байдлаар 21 аймгийн 35 экспедиц, 14 аймгийн 28 газрын генератор үйл ажиллагаа явуулахад байнгын бэлэн байдалтай байна.
- Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор орон нутгийн сум дундын ойн ангиуддад ОХУ-д үйлдвэрлэсэн Фургон маркийн 22 автомашиныг олгоод байна.
- Гамшгийн голомтод ажиллаж буй онцгой байдлын албан хаагчдад нэн шаардлагатай хүн нэг бурийн галын аюулгүйн хучлага-500 ширхэг, үлээгч аппарат-362 ширхэг, үүргэвчтэй ус шүршигч-200 ширхэг, хамгаалалтын нүдний шил-821 ширхэгийг тус тус худалдан авахад шаардагдах нийт 600,0 сая төгрөгийн санхүүжилтыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг 2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлээд байна.

### **1.3. Ой, хээрийн түймрийн өнөөдрийн цагийн байдал:**

2015 оны 02 - р сарын 4-нөөс эхлэн ой хээрийн түймэр гарч 2015 оны 4-р сарын 27-ны 21 цагийн байдлаар нийт 111 удаагийн ой, хээрийн түймэр бүртгэгдэж 15 аймгийн 59 сумын нутаг дэвсгэр хамрагдсан байна. Түймрээс учирсан хохирлыг урьдчилсан байдлаар авч үзвэл нийт 4,783,853 гаруй га тал хээр, бэлчээрийн газар, 146,459 га ой, нийт 4.930.313 га ой, бэлчээрийн талбай шатжээ.

Түймэрт 40 гаруй айлын гэр, 20 гаруй өвөлжөө хаваржаа, саравч, зам ангийн 1 машин шатаж, 4000 гаруй толгой мал нэрвэгдсэн байна. Түймрийг унтраахад ОБЕГ-аас давхардсан тоогоор 1600 албан хаагч, 102 автомашин, Хилийн цэргээс 420 албан хаагч, 24 автомашин, Цагдаагийн байгууллагаас 45 албан хаагч, Орон нутгаас 3000 иргэн, 543 автомашин, 60 мотоцикл, нийт 5000 гаран хүн, 418 автомашин, 47 мотоцикл, 2 нисдэг тэрэг тус тус дайчлагдан ажилласан байна. ОХУ-аас улсын хил давж 8 удаа хээрийн түймэр орж ирсэн. Монгол улсаас БНХАУ-ын хил давж 4 удаа хээрийн түймэр гарчээ.

Гарсан түймрүүдийг аймгуудаар авч үзвэл, Архангай, Баян-Өлгий, Булган, Өвөр-Хангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Говь сүмбэр, Ховд, Хэнтий, Дорнод, Дархан-Уул, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт тус тус гарчээ. Түймрийн эзэн шалтгаан, талбай, учирсан хохирол одоогоор бүрэн тогтоогдоогүй байна.

Түймэр гарсан шалтгааныг айлын үнстэй нурам болон ОХУ-аас хил давж ирсэн түймрээс гарчээ гэж урьдчилсан байдлаар тогтоогоод байна.

#### **Цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ:**

1. Үүлэнд зориуд нөлөөлөх борооны JFJ-1A маркын хийцийн пуужин 500 ширхэгийг худалдан авч нөөц бүрдүүлэх
2. Түймэр унтраах зориулалтын үлээгч аппарат, галд тэсвэртэй зориулалтын хувцас, бусад хэрэгслээр байгаль хамгаалагч, ойн ажилтан нарыг хангах арга хэмжээ авах
3. Түймрээс хамгаалах зурvas гаргах туулах чадвар сайтай трактор, анжсаар орон нутгийн төрийн захиргаа, байгаль орчны байгууллагуудыг хангах, нэмэлт санхүүжилт олгох
4. Түймрээс сэргийлэх сурталчилгааны ажлыг нэмэгдүүлэх, учирсан хохирол, эзэн холбогдгүйг тогтоох, хариуцлага хүлээлгэх ажлын үүргийг холбогдох газруудад өгч, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг ажлыг төлөвлөөд байна.

#### **II. Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын талаар**

Өнгөрсөн хугацаанд тохиолдсон цаг агаарын гамшигт болон аюултай үзэгдлийн талаар урьдчилан сэргийлэх мэдээг тухай бүрд сэргэжлүүлэх дохиотой болон анхааруулах мэдээг гарган иргэд, олон нийт, холбогдох байгууллагуудад хүргүүлж байсан бөгөөд уг үзэгдлүүдийг бүрэн мэдээлж чадсан байна.

Тухайлбал, 2015 оны 4 дүгээр сард тохиолдсон их цас, цасан шуурга, шороон шуурга, их халуун, хүчтэй салхины талаарх гамшигт үзэгдлийг Ус цагуур орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Урьдчилан мэдээлэх төвөөс 3 сарын 30-наас эхлэн 5 хоногийн

өмнөөс анхааруулж, малчид ард иргэдэд анхааруулах мэдээ хүргэв. 2015 оны 4 сарын 3-нд Өвөрхангай, Төв, Дундговь аймгийн нутгаар их цасны, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутгаар цасан шуурганы, Дундговь, Дорноговь аймгийн нутгаар хүчтэй салхины онц аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг 24 цагийн өмнө гаргаж хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай дамжуулж ажилласан болно.

**A. 2015 оны 04 сарын 3-4-ний өдрүүдэд болсон их цас, цасан шуурганы гамшигт үзэгдлийн тухай**

2015 оны 4 дүгээр сарын 3-нд Увс, Завхан, Хөвсгөл, Булганы нутаг, Баянхонгорын хойд хэсгээр 0.0-9.0мм, 4-нд Архангай, Өвөрхангай, Төв, Хэнтий, Дундговийн нутгаар 0.0-11.0мм их цас орж салхи 4-нд Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дундговь, Өмнөговь, Дорноговийн нутгаар секундэд 10-24 метр хүрч хүчтэй цасан болон шороон шуурга шуурсан байна.

**B. 2015 оны 4 дүгээр сарын 11-15 нд огцом дулаарах, нойтон цас, хүчтэй цасан болон шороон шуурганы талаар**

4 дүгээр сарын 11-нд баруун аймгуудын нутгаар, 12-13-нд ихэнх нутгаар, 14-нд нутгийн зүүн хагаст эрс дулаарч өдөртөө ихэнх нутгаар +15...+20 градус,.govийн аймгуудын нутгаар 25 градус хүрч дулаарна.

2015 оны 4 дүгээр сарын 13-нд баруун аймгуудын нутгаар, 14-нд Баруун болон Төв, Говийн аймгуудын нутаг, Улаанбаатар хотод, 15-нд нутгийн зүүн хагаст хур тунадас, нойтон цас орж, салхи өмнөөсөө хойш эргэж 16-18 м/с, Говь, талын зарим нутгаар 24 м/с хүрч хангайдаа хүчтэй цасан шуурга, говьдоо шороон шуурга шуурч эрс сэргүүсэх нөхцөл бүрдэх төлөвтэй байна.

Иймд цас, шуурга, хүйтрэлтийн улмаас зам даваа хаагдах, халтиргаа гулгаа үүсэх, үзэгдэх орчин муудаж, мал салхи шуурганд уруудах, дулаан хувцасгүй хүмүүс даарч осгож болзошгүй тул урьдчилан сэргийлэх арга хэмжээг яаралтай авахыг 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Монгол улсын шадар сайд, Улсын онцгой комиссын дарга У.Хүрэлсүх, БОНХАЖ-ын сайд, ХХАА-н сайд, ОБЕГ-ын дарга, Нийслэлийн засаг даргад хүргүүлэн ажилласан байна.

**В. Монгол орны нутагт 2015 оны 4 дүгээр сарын 20-26-ний өдрүүдэд зориудаар хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулсан тухай мэдээлэл**

2015 оны 4 дүгээр сарын 17-19 нд Дархан-Уул аймагт 2 удаа, Хэнтий аймгийн Батширээтийн газрын генератор 1 удаа, Ховд аймгийн Дуутын газрын генератор 1 удаа /4 ширхэг түлш/, Хэнтий аймгийн 2 экспедиц Баян-Адрага, Дадал сумдын нутагт 3 удаа /6 ширхэг пуужин/, Өмнөговь аймгийн Баяндалайн газрын генератор 1 удаа /4 түлш/, нийт 2 аймгийн 3 экспедиц, 3 аймгийн 3 газрын генератор үүлэнд нөлөөлөх ажилбар явууллаа.

2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Дорнот аймгийн экспедиц Матад сумын чиглэлд гарч, үүл тандалт явуулсан боловч үүлний хэмжээ маш бага, салхины хурд үе үе 20м/с-ийг давж салхилан, нөхцөл бүрдээгүй учраас ажиллаагүй буусан. 4 дүгээр сарын 25-26-нд шилжих шөнө Хөвсгөл аймгийн 1 экспедиц /9 пуужин/ Арбулаг, Алаг-Эрдэнэ сумын “Эрхэл нуурын хөндий”, Тосонцэнгэл сумын “Баян-Эрхэт” гэдэг газарт 3 удаа,

Цагаан-Уул сумын "Агар" багт газрын генератор 03,35 цагт 1 удаа /4 түлш/ үүлэнд зориудаар нөлөөлснөөр аймгийн ихэнх нутгийг хамарч 0,5-18,0 мм тунадас орсноос Түнэлд 18,0мм, Баянзүрхэд 16,0мм, Эрдэнэбулганд 13,0мм, Тариаланд 12,0мм, Мөрөнд 8,0мм, Арбулагт 10,0мм, Алаг-Эрдэнэд 6,0 мм бороо орсон байна.

2015 оны 4-р сарын 5-наас хойш Зүүн аймгуудын нутгаар үүлэнд зориудаар нөлөөлөх тохиромжтой цаг агаарын нөхцөл бүрдэхгүй, салхи шуурга ихтэй, багахан хэмжээний үүлний масст нөлөөлөх оролдлого хийсэн ч төдийлэн үр дүнд хүрэхгүй байна.

#### БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ